

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2021 ОНЫ 7 ДУГААР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД

Аймгийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж, 2 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг ханган ажилласан. Засаг даргын зөвлөлийн хурал 2 удаа зохион байгуулж, 4 асуудал хэлэлцэж шийдвэрлэсэн.

Эрүүл мэндийн яам, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 2021-2023 оны хугацаанд “Говьсүмбэр аймгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний чадавхийг сайжруулах” төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, Эрүүл мэндийн яам, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын төлөөлөл, нийт 13 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг орон нутагт ажилласан. Тус төслийн хүрээнд аймгийн анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад мобайл технологийг үе шаттайгаар нэвтрүүлж, 37.1 сая төгрөгийн 8 нэр төрлийн 24 ш тоног төхөөрөмжийг эхний ээлжид хүлээлгэн өглөө. Мөн ДЭМБ-аас аймгийн Нэгдсэн эмнэлэгт 172.0 сая төгрөгийн өртөг бүхий ПГУ аппарат болон дагалдах хэрэгслүүдийг нийлүүлэхээр шийдвэрлэсэн.

Коронавирус (ковид-19) халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний хүрээнд: “Коронавируст халдвар /ковид-19/-ын эрсдэлээс урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээ авах тухай” аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/172 дугаар захирамжаар 8 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд өндөржүүлсэн бэлэн байдлын улбар шар түвшинд шилжин ажиллаж байна. 2021 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар нийт халдварын тоо 719, эдгэрсэн 651, эмчлэгдэж байгаа 65 иргэн байна. Гэрийн ажиглалтад 410 иргэн байгаад хяналт тавин ажиллаж байна.

Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг дархлаажуулалтын үйл ажиллагааг аймгийн хэмжээнд 1 түр цэг, 3 байнгын цэг, явуулын 2 багаар зохион байгуулан ажиллаж, Синофарм үйлдвэрлэгчийн Вероцелл вакцин, Пфайзер үйлдвэрийн Комернити вакциныг нийт 27175 хүн тунг татан авч 86.5 хувийг зарцуулаад байна. Вакцины 1 дүгээр тунд тус аймагт бүртгэлтэй 18-аас дээш насны 12279 иргэн, 2 дугаар тунд тус аймагт бүртгэлтэй 18-аас дээш насны 11237 иргэн, Пфайзер үйлдвэрийн Комернити вакцинд 12-17 насны 1705 хүүхэд хамруулахаас 1 дүгээр тунд 1494, 2 дугаар тунд 838 хүүхэд хамрагдаад байна.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, орлого бүрдүүлэлтийг эрчимжүүлэн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд хангах биелүүлэхэд анхаарч ажиллаж, 2021 оны 7 дугаар сарын нийт татварын орлогын төлөвлөгөө 3,714,172 мянган төгрөг төвлөрүүлэхээс 4,582,458 мянган төгрөг төвлөрүүлж, 23 хувиар төлөвлөгөөг давуулан биелүүлээд байна. Үүнээс улсын төсвийн орлогын төлөвлөгөө 648,978 мянган төгрөг төвлөрүүлэхээс 649,000 мянган төгрөгийг төвлөрүүлж 100 хувь төвлөрүүлсэн бол сумын төсвийн орлогын төлөвлөгөө 484,458 мянган төгрөг төвлөрүүлэхээс 673,700 мянган төгрөг төвлөрүүлж 39 хувиар, аймгийн төсвийн орлогын төлөвлөгөө 2,542,436 мянган төгрөг төвлөрүүлэхээс 3,259,758 мянган төгрөг төвлөрүүлж 28 хувиар давуулсан гүйцэтгэлтэй байна.

2021 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар татвар төлөгч хуулийн этгээд нийт 654 болж, 2021 оны эхэн үетэй харьцуулахад 25-аар нэмэгдсэн. Татвар төлөгчдийг хариуцлагын хэлбэрээр харуулбал: ХК-1, ХХК-343, ББН-5, ЗБН-9, Хоршоо-24, ХЗХоршоо-1, ОНӨҮГ-6, Салбар-64, төсөвт болон төрийн бус байгууллага, сан ОНБ-201 байна.

1 аж ахуй нэгжид 2017-2020 оны татвар, санхүүгийн баримт материал, татварын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж 1,613,781.27 төгрөгийн нөхөн ноогдуулалтын акт үйлдсэн.

Санхүүгийн хяналт, аудитын чиглэлээр: Аймгийн хэмжээнд нийт төсвийн болон орон нутгийн өмчит 77 байгууллагын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.

6 дугаар сард шилэн дансны хуулийн хэрэгжилт 98.4 хувь буюу өмнөх сараас 4.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Илчлэг Шивээ ОНӨААТҮГазрын 2020-2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж, нийт 162,609.3 мян.төгрөгийн зөрчил илрүүлснээс 11,032.5 мянган төгрөгийн нөхөн төлбөрийн акт, 75,607.3 мян.төгрөгийн хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

Мөн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2019-2021 оны санхүүгийн үйл ажиллагаа болон газрын төлбөр ногдуулалтад төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж, нийт 45,557.7 мян.төгрөгийн зөрчил илрүүлснээс 4,522.3 мянган төгрөгийн нөхөн төлбөрийн акт, 1,668.4 мян.төгрөгийн хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

Нийгмийн даатгалын сангаас олгосон: Тэтгэвэр

| № | Төрөл | 2020.07.25 | | 2021.07.25 | |
|-----------------|----------------------|-------------|--------------------------|-------------|--------------------------|
| | | Хүний тоо | Тэтгэврийн дүн /мян.төг/ | Хүний тоо | Тэтгэврийн дүн /мян.төг/ |
| 1 | Өндөр настан | 1802 | 5403124.7 | 1917 | 6222809 |
| 2 | Хөгжлийн бэрхшээлтэй | 341 | 862832.5 | 305 | 736876 |
| 3 | Тэжээгчээ алдсан | 128 | 278087.3 | 121 | 288849.5 |
| 4 | Үйлдвэрийн осол | 27 | 99609.3 | 46 | 170198.7 |
| Нийт дүн | | 2298 | 6643653.8 | 2389 | 7418733.2 |

Нийгмийн даатгалын сангаас олгосон: Тэтгэмж

| № | Төрөл | 2020.07.25 | | 2021.07.25 | |
|-----------------|--------------|-------------|--------------------------|------------|--------------------------|
| | | Хүний тоо | Тэтгэмжийн дүн /мян.төг/ | Хүний тоо | Тэтгэмжийн дүн /мян.төг/ |
| 1 | ХЧТА тэтгэмж | 695 | 94855.5 | 535 | 63225.3 |
| 2 | ЖБА тэтгэмж | 238 | 395341.6 | 261 | 496856.5 |
| 3 | Оршуулга | 41 | 41000 | 44 | 44000 |
| 4 | ҮОМШӨ-ХЧТА | 3 | 4521.5 | 14 | 13024.8 |
| 5 | Ажилгүйдэл | 435 | 281798.1 | 111 | 225489 |
| Нийт дүн | | 1412 | 817516.7 | 965 | 842595.6 |

Сайн дурын даатгал:

| Сайн дурын даатгалын хамрагдалт | 2020.07.25 | 2021.07.25 |
|---------------------------------|------------|------------|
| Шинээр | 289 | 202 |
| Мөнгө тушаасан | 504 | 467 |
| Тушаасан мөнгөн дүн / мян.төг/ | 88792.2 | 106646.2 |

ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд 44 заалт, 218 хүний нэр, 44 байгууллагын нэр, 134 газар зүйн нэр, 61 хуудас баримт программд холбосон. Архивын баримтаас 11 иргэнд лавлагаа мэдээлэл олгох үйлчилгээ үзүүлсэн.

Иргэний бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр гадаад паспорт захиалсан - 11
- Иргэний үнэмлэх шинээр олгосон - 4
- Төрснөө бүртгүүлсэн хүүхдийн тоо - 30
- Гэрлэлт бүртгүүлсэн тоо - 1
- Нас барсныг бүртгүүлсэн тоо - 6
- Өөр аймаг, хотоос шилжиж ирсэн нийт иргэн - 15
- Аймаг дотор шилжсэн иргэдийн тоо - 14

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр:

- Үл хөдлөх хөрөнгийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 4
- Газар өмчлөх эрхийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 12

- Гэрээний бүртгэл - 76
- Барьцааны гэрээний бүртгэл - 187
- Эд хөрөнгөд орсон өөрчлөлт, залруулга - 9

Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн бүртгэл - 6
- Хуулийн этгээдийн бүртгэлийн өөрчлөлт - 4

Архивын чиглэлээр:

- Төрийн байгууллагад гаргасан лавлагаа, хуулбар - 134
- Иргэнд гаргасан лавлагаа, хуулбар - 61

Нийт 574 иргэнд төрийн үйлчилгээг үзүүлсэн.

Цагдаагийн хэлтэс: 2021 оны 07 дугаар сард иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 140 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаснаас гэмт хэргийн 16, зөрчлийн 124 өргөдөл, гомдол байна.

Тайлант хугацаанд зөрчил гаргасан 2117 иргэнийг нийт 85,255.0 мянган төгрөгөөр торгож, согтуугаар зөрчил гаргасан 69 хүнийг эрүүлжүүлж, 10 хүнийг шүүхээр баривчлуулан, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хассан.

Бүх нийтийн амралтын өдрүүдээр аймгийн Онцгой байдлын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Сүмбэр сумын хамтарсан багтай хамтран эргүүл, шалгалт зохион байгуулж, аялал, зугаалгаар явж байгаа 800 иргэнд гол, нуурын усны болзошгүй осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг зөвлөмж өгч ажилласан.

Зам тээврийн осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх “Орон нутгийн зам–Хөдөлгөөний соёл-2021” нэгдсэн арга хэмжээний хүрээнд хүүхдийг зам тээврийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Ирээдүйгээ хамгаалъя” аяныг зохион байгуулж байна. Аяны хүрээнд “Саруул харгуй” ХХК-тай хамтран аймгийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрдөг босоо тэнхлэгийн замд байрлах урьдчилан сэргийлэх мэдээллийн самбруудад “Ирээдүйгээ хамгаалъя” уриатай хэвлэлийг хийж байршуулаад байна. Мөн 2021 оны 07 дугаар сарын 04-07-ны өдрүүдэд Баянтал сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт Оорцог энгэр зөрлөгөөр дамжин өнгөрөх босоо тэнхлэгийн хатуу хучилттай А0101 дугаартай улсын чанартай авто замын хөдөлгөөнд хяналт тавьж, аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг авто сургуулиуд болон хүнсний дэлгүүрүүд, Монгол даатгал ХХК, Ард даатгал ХК, аймгийн Говьсүмбэр телевизтэй хамтран жолооч нарт зөвлөгөө өгөн ажиллаж, амин дэм, гарын бэлэг гардуулан өгсөн.

Шүүхийн шинжилгээний алба: Хэргийн газрын үзлэгт 31 удаа оролцсон. Үүнээс хүний амь нас хохирсон 6, зам тээврийн ослын 8, хулгайлах гэмт хэрэг 4, бусад хэргийн газрын үзлэгт 13 удаа оролцон хэргийн газрын үзлэгийн болон эд мөрийн баримт, эрэн сурвалжлах, танин олуулах ажиллагаа, хэргийн газрын давтан үзлэг, нэгжлэг, цогцос задлан шинжлэх зэрэг ажиллагааны 480 кадр гэрэл зургийг боловсруулан, холбогдох материалд хавсаргасан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 425 дугаар нээлттэй хорих анги: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага үүсч хөгжсөний түүхт 100 жилийн ойн хүрээнд “Дурсамжит нэг өдөр” арга хэмжээг зохион байгууллаа.

Хорих ангид хоригдож байгаа хүмүүсийг мэргэжил эзэмшүүлэх зорилгоор Уул уурхайн жишиг сургууль Политехник коллежтой хамтран ажиллаж ирсэн бөгөөд тайлант хугацаанд 3 хүмүүжигчийг уулын ажлын техникч мэргэжлээр сургасан. Мөн 19 төрлийн дугуйланг ажиллуулж, хүмүүжигчдийг хамруулж байна.

2021 оны 07 дугаар сард 174 гүйцэтгэх баримт бичгийн 2,667,615.6 мянган мянган төгрөг төвлөрүүлэхээс 61 гүйцэтгэх баримт бичгийн 763,456.2 мянган төгрөг төвлөрүүлж, 113 гүйцэтгэх баримт бичгийн 1,904,159.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, бодит биелэлт 35 хувьтай байна.

Мэргэжлийн хяналтын газар: Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу Сүмбэр сумын 1 дүгээр багт байрлах уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлт, үйлдвэрлэлийн бүсэд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаанд 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдөр хяналт шалгалтыг хийж, байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн 5 аж ахуй нэгж байгууллагад 10.0 сая төгрөгийн, иргэнээс ирүүлсэн 1 гомдлын дагуу халдвар хамгааллын дэглэм зөрчиж ажилласан хүнсний дэлгүүрт 500,000 төгрөгийн торгууль, нийт 10,500,000 төгрөгийн торгох шийтгэл оногдуулж, орон нутгийн орлогод төвлөрүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 118 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 41 дүгээр тушаалаар батлагдсан “Коронавируст халдвар (Ковид-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам”, аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 02-ны А/162 дугаар захирамж, түр журмын тусгай нөхцөл, шаардлагыг хангах ажлын хүрээнд эрүүл ахуй, халдвар хамгаалал, хүнсний чанар, стандартын хяналтаар үйл ажиллагааг хязгаарлаагүй бүх чиглэлийн худалдаа, үйлчилгээний байгууллага, хоол үйлдвэрлэл эрхэлж байгаа 35 объектод хяналт шалгалт хийж, 34 зөрчил илрүүлж, зөрчлийн 64.7 хувийг газар дээр нь арилгуулж, 1 аж ахуйн нэгжид хугацаатай албан шаардлага хүргүүлэн, холбогдох чиглэлээр зөвлөгөө өгөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд төлөвлөгөөт шалгалт 4, зөвлөн туслах 2, төлөвлөгөөт бус 5, урьдчилан сэргийлэх 1 шалгалт хийж, 3 аж ахуйн нэгжид албан шаардлага, 5 аж ахуйн нэгжид дүгнэлт, 10 аж ахуйн нэгжид зөвлөмж хүргүүлсэн. Мөн шаардлага хангахгүй хугацаа дууссан 3 төрлийн 104,000 төгрөгийн үнэ бүхий хүнсний бүтээгдэхүүнүүдийг газар дээр нь устгалд оруулсан.

Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч, эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч болон аж ахуй нэгж байгууллага, иргэний хүсэлтээр ирүүлсэн усны 14, ариутгалын бодисын 1, хүнсний бүтээгдэхүүний 16, арчдасны 20, нийт 51 сорьцод 184 үзүүлэлтээр хими, нян судлалын шинжилгээг гүйцэтгэж, эерэг үзүүлэлт 3 илэрснийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

Онцгой байдлын газар: Ариутгал халдваргүйтгэлийн тусгай тоноглол автомашинаар Баянтал, Шивээговь сумын багуудад урьдчилан сэргийлэх ариутгал халдваргүйжүүлэлтийг 355000 м.кв талбайд хийсэн.

Монгол Улсын Шадар Сайд, Онцгой байдлын газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд Уул уурхай баяжуулах үйлдвэрийн барилга байгууламжид Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай, Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай хууль болон стандарт, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 4 газарт зохион байгуулан ажилласан.

Норм, нормативын хэрэгжилтийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байгаа 5 объектод ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт гаргаж, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн дагуу 845000 төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлэн ажилласан.

ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Боловсролын чиглэлээр: Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх “Сорилго-3” шалгалтын дүнгийн хурлыг онлайн ариутгал зохион байгуулж, мэргэжлийн 40 багшийг хамруулсан. Үнэлгээний шинжээч багш нарт 2021 оны “Элсэлтийн ерөнхий шалгалт”-ын бюпринтийг танилцуулж, анги бүрийн агуулгын харьцаа, даалгавар бүрийн шинжилгээг гүйцэтгэл доогуур агуулга бүрт өгч, санал солилцож, зөвлөмж өгч, Сорилго-1,2,3 шалгалтуудын хүрээнд нийт 1352 даалгаврын шинжилгээний боловсруулалтыг эмхтгээд байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр: Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын зуны амралтыг үр дүнтэй өнгөрүүлэх зорилгоор хэрэгжиж буй "PEACE ROAD" амьдрах ухааны

цахим хөтөлбөр хэрэгжиж эхлээд байна. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд 6-9, 10-12 дугаар ангийн 2 бүлэгт 12 цагийн хичээлийг цахимаар зохион байгууллаа.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэргэдэх сэтгэл зүйн төвөөс Коронавирус /ковид-19/-т халдвараар өвчилсөн 118 хүүхэд, 276 насанд хүрэгчдэд утсаар сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлэн ажилласан.

Гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжих, харилцаа холбоог нэмэгдүүлэх зорилгоор "Гэр бүлийн харилцаа" сургалтыг зохион байгуулж, Цагдаагийн хэлтсийн 31 албан хаагчийг гэр бүлийн хамт хамруулсан.

Хүүхэд, гэр бүлийн эрсдэлийг тодорхойлох түргэвчилсэн үнэлгээ хийх судалгаа авах ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулан, зорилтот бүлгийн 105 өрхийг хамруулсан.

Соёл, урлагийн чиглэлээр: Сан хөмрөгийн эд өлгийн эрсдэлийн судалгааг Соёлын өвийн үндэсний төвтэй хамтран 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 08 дугаар сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулах ажлыг эхлүүлж, туршилт, тандалт судалгааг явуулж байна.

Соёлын өвийн үндэсний төв, Шинжлэх ухааны археологийн хүрээлэнгийн дэмжлэгтэйгээр "Титанс Пикчерс" ХХК-ийн санаачилгаар хэрэгжүүлж буй "Монгол орны үзэсгэлэнт байгаль, түүхэн дурсгалт газар"-ууд төслийн хүрээнд орон нутгийн байгаль, соёлын биет болон биет бус өв, түүх соёлын үл хөдлөх дурсгалын талаарх нэвтрүүлгийг Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн Боржигин өв музей, орон нутгийн иргэдтэй хамтран бэлтгэсэн.

Эрүүл мэндийн чиглэлээр:

| Үзүүлэлт | 2020 оны 07 сар сарын байдлаар | 2021 оны 07 сарын 20-ны өдрийн байдлаар |
|-------------------------------------|--------------------------------|---|
| Төрсөн эх | 265 | 254 |
| Гэрийн төрөлт | 0 | 0 |
| Амьд төрсөн хүүхэд | 268 | 258 |
| Амьгүй төрөлт | 0 | 0 |
| Нас баралт | 45 | 40 |
| Эмнэлгийн нас баралт | 2 | 10 |
| Хоног болоогүй нас баралт | 0 | 5 |
| 0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл | 0 | 1 |
| 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл | 2 | 0 |
| Эмнэлгээс гарсан хүний тоо | 2739 | 2136 |
| Амбулаторийн үзлэг | 57194 | 56061 |
| Халдварт өвчин | 64 | 664 |

2021 оныг аймгийн хэмжээнд “Нийтийн эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарласан бөгөөд үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд “Эмчийн цаг” нэвтрүүлгээр “Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх нь” сэдвээр цахим сургалт явуулж, нийтэд түгээж байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлэгт эмгэг судлалын лаборатори байгуулж, улсын төсвийн хөрөнгөөр 25.0 сая төгрөгийн өртөг бүхий эд зүсэгч микротон, Мянганы сорилтын сангийн санхүүжилтээр микроскоп, компьютер олгож, ашиглалтад орууллаа.

Эрүүл мэндийн яамнаас 91.0 сая төгрөгийн хамгаалах хувцас, ариутгалын бодис эмнэлгийн хэрэгсэл, 5ш олон үйлдэлт эмнэлгийн ор хүлээн авч, эмчилгээ үйлчилгээнд ашиглаж байгаа.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний чиглэлээр: Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөөнд 38 иргэнийг хамруулсан. 2021 оноос хойш өссөн дүнгээр 169

иргэнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөх үйлчилгээг үзүүлж, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.

Ажил олгогч аж ахуй нэгж байгууллагаас 77 сул, чөлөөтэй ажлын байрны захиалгыг авч, бүртгэлтэй ажил хайгч иргэдэд утсаар болон цахим мэдээллийн хэрэгслээр хүргэн, байнгын ажлын байр 3, түр ажлын байранд 62, нийт 65 иргэнийг ажлын байранд зуучилсан.

Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрт хамрагдахаар 10 иргэн төсөл ирүүлснээс, 7 иргэнд 3,500.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгоод байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 17 иргэн төсөл ирүүлснээс 8 иргэнд 2,800.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон.

Хөтөлбөрүүдийн санхүүгийн дэмжлэг арга хэмжээний хүрээнд төсөл өгсөн иргэдийг сургалтын эрх бүхий байгууллага болох “Хөгжлийн Шийдэл” ТББ-тай хамтран “Бизнес эрхэл” сэдэвт аж ахуй эрхлэлтийн сургалтыг 56 иргэнд цахимаар зохион байгуулж байна.

Нийтийг хамарсан ажил арга хэмжээний хүрээнд нийт 47 иргэнийг түр ажлын байраар хангаж, 11,368.0 мянган төгрөгийн цалинг олгоод байна.

2018-2020 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг арга хэмжээнд хамрагдсан 58 иргэний 48,294.3 мянган төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлж ажилласан. Үүнээс тайлант хугацаанд 36 иргэний 10,337.0 мянган төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлээд байна.

ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Бэлчээр хамгаалах, сайжруулах, зохистой ашиглах, оновчтой төлөвлөх сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Бэлчээр хамгаалах улирал” аяныг Хүнс, Хөдөө аж ахуйн газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газар, Малчдын бүлгүүдтэй хамтран хэрэгжүүлж байна. Тус аяны хүрээнд Сүмбэр сумын 5 дугаар баг Улсын тусгай хамгаалалттай “Чойрын богд уул”-ын эргэн тойронд байгаа 24 малчин өрхийн төлөөлөлтэй уулзаж, тэдний саналаар 36 малчин өрхийг гурван бүлэг болгон зохион байгуулалтад оруулсан. Мөн бэлчээр өтгөрүүлэх, малын тэжээл тариалах сонирхол бүхий 12 малчин өрхөд 116 кг нэг болон олон наст тэжээлийн ургамлын үрийг хуваарилан олгосон.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хэрэгжиж буй “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төсөл”-ийн хүрээнд олгосон тусламжийн хүнсний 300 багцыг аймгийн Засаг даргын 2021 оны А/87 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсэг хүлээн авч, малчдад хүргэсэн.

Аймгийн хэмжээнд гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад 574 өрхийн, 16864 үхэр, 250626 хонь, 195958 ямаа, 28 гахай, нийт 463476 мал, амьтныг хамруулж, гүйцэтгэл 96 хувьтай байна.

2021 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн байдлаар 40 иргэн, 1 аж ахуйн нэгж, 4 байгууллага 26.5 га талбайд төмс, 25.8 га талбайд хүнсний ногоо, 6.2 га талбайд тэжээлийн ургамал, 0.07 га талбайд жимс, жимсгэнэ тариалж, тариалалтын төлөвлөгөө 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүнсний бодит нөөцийн хэмжээ аймгийн дүнгээр мах 1.1 тн буюу 1, гурил 91.1 тн буюу 65, сүү 3.5 тн буюу 2, төрөл бүрийн будаа 22.3 тн буюу 32, төмс 7.8 тн буюу 5, хүнсний ногоо 6.6 тн буюу 2, элсэн чихэр 3.3 тн буюу 7, давс 2.9 тн буюу 11, савласан ус 14.2 тн буюу 1, өндөг 1.1 тн буюу 4, ургамлын тос 4.2 тн буюу 14 хоногийн нөөцтэй байна.

Хоршоо, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдөр ЭС ЭФ СИ ЭС ХХК-тай хамтран “Хөдөө аж ахуйн органик бүтээгдэхүүн үйлдвэрлэл” “Бүтээгдэхүүн, үйл явц, үйлчилгээ, менежментийн тогтолцооны баталгаажуулалт” сэдвээр цахим сургалт зохион байгуулав. Тус арга хэмжээнд 13 аж ахуйн нэгжийг хамруулсан.

2019 оны ЖДҮДС-ийн зээлд хамрагдсан 9 аж ахуй нэгжээс 2 зээлдэгч зээлээ бүрэн төлж дууссан. Зээлийн үлдэгдэлтэй 7 зээлдэгчийн 394,400,000.00 төгрөг төвлөрүүлэхээс

75,940,483.00 төгрөгийн зээл төлж хүүгийн төлөлт 33,110,280.00 төгрөг төвлөрүүлж, 318,459,517.00 төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.

Аймгийн төвийн захууд, томоохон худалдааны төвүүдийн хүнсний бараа бүтээгдэхүүний харьцуулсан үнэ /2021 оны 7 дугаар сарын байдлаар/

Зах зээлд худалдаалагдаж буй зарим хүнсний бараа бүтээгдэхүүний үнэ өнгөрсөн сараас 50-100 төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Тухайлбал: лууван /монгол/ 50 төгрөгөөр, төмс 50 төгрөгөөр нэмэгдсэн бол үхрийн мах /ястай/ 250 төгрөгөөр, үхрийн мах /цул/ 500 төгрөгөөр, хонины мах /цул/ 500 төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Бусад бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байна.

| № | Бараа бүтээгдэхүүн | Дээд үнэ төг | Доод үнэ төг | Өссөн буурсан /5-р сараас / | |
|----|---------------------|----------------------------|--------------|-----------------------------|------|
| 1 | Үхрийн мах | Ястай | 10000 | 10000 | -250 |
| | | Цул | 12000 | 11000 | -500 |
| 2 | Хонины мах | Ястай | 9000 | 8500 | - |
| | | Цул | 11000 | 10000 | -500 |
| 3 | Адууны мах | Ястай | 6500 | 6000 | - |
| | | Цул | 8500 | 8000 | - |
| 4 | Ямааны мах | Ястай | 7000 | 6500 | - |
| | | Цул | 8500 | 8000 | -500 |
| 5 | Лууван | монгол | 1900 | 1000 | 50 |
| | | хятад | | | |
| 6 | төмс | монгол | 1400 | 850 | 50 |
| | | хятад | | | |
| 7 | Байцаа | монгол | 2000 | 1800 | - |
| | | хятад | | | - |
| 8 | чинжүү | монгол | 8500 | 7000 | - |
| | | хятад | 7500 | 4500 | |
| 9 | Манжин | монгол | 2000 | 1500 | |
| | | хятад | | | - |
| 10 | Сонгино бөөрөнхий | Монгол | 4000 | 1800 | - |
| | | Хятад | - | 1400 | - |
| 11 | Помидор | монгол | 7500 | 5500 | - |
| 12 | Өргөст хэмх | монгол | 7500 | 6500 | - |
| 13 | Элсэн чихэр | монгол | 3000 | 2300 | - |
| 14 | Будаа | Цагаан задгай кг | 3000 | 2400 | - |
| | | Шар слава кг | 3500 | 3000 | - |
| | | Гурвалжин будаа кг | 3800 | 2200 | - |
| 15 | Сүү | Задгай | 3450 | 3000 | - |
| | | Сүү ХХК 0,5л | | | |
| | | Сүү ХХК 1л | 3200 | 2900 | - |
| 16 | Тараг | Задгай | 2200 | 2000 | - |
| | | Сүү ХХК 1л цөцгийтэй тараг | 4800 | 3800 | - |
| 17 | Талх | Чойр талх | 1200 | 1150 | - |
| 18 | Өндөг | Монгол | 550 | 450 | - |
| 19 | Алтан тарианы гурил | Задгай дээд | 1520 | 1480 | |
| | | Задгай 1-р зэрэг | 1210 | 1100 | - |
| | | Задгай 2-р зэрэг | 1000 | 950 | - |
| | | Савласан д/дээд / | 2400 | 2300 | - |
| | | Савласан дээд | 2200 | 2100 | - |

| | | | | | |
|----|--------------|--------------------|------|------|---|
| | | Савласан зэрэг 1-р | 1400 | 1300 | - |
| | | Савласан зэрэг 2-р | 1500 | 1450 | - |
| 20 | Ургамлын тос | Олейна | 5500 | 5200 | - |
| | | Алтан | 4500 | 4500 | - |

ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Байгаль орчны чиглэлээр: Цөлжилттэй тэмцэх, газрын доройтлыг бууруулах ажлын хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас цөлжилтийн төлөв байдлыг бууруулах, хамгаалах чиглэлээр цахим сургалт зохион байгуулж, Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд манай аймагт 2021 онд 25 га талбайд цөлжилтийг сааруулах элсний нүүлтээс хамгаалах, хамгаалалтын зурвас байгуулж буй ажлын явц болон тулгамдаж буй асуудлын талаар санал хүргүүлж ажилласан.

Улсын тусгай хамгаалалттай “Чойрын богд” ууланд нутагшдаг зэрлэг амьтдын тандалт судалгаа болон хууль бус ан агнуураас урьдчилан сэргийлэх зорилгоор 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрөөс 07 дугаар сарын 22 хүртэлх хугацаанд Чойрын Богд уулын орчимд эргүүл шалгалтын ажил хийж гүйцэтгэж, гарсан зөрчилгүй байна.

Сүмбэр сумын 5 дугаар багийн нутаг Чойрын Богд уул, Мухар, Цоорхойн рашаан, Цагаан дарь эх, Уулзварын гол, Асгана булаг, Төмөр утасны хороо зэрэг газруудаар 07 дугаар сарын 10-ны өдрөөс 07 дугаар сарын 19-ний өдрийн хооронд аялал зугаалга ихэссэнтэй холбогдуулан 413 иргэнд хог хаягдал хаяхгүй байх заавар зөвлөмж өгч, зөвшөөрөлгүй газар хог хаясан 1 иргэнд мэдэгдэж Цоорхойн рашаан, Цагаан дарь эх зэрэг газруудын хогийг цэвэрлүүлсэн.

Шивээ-Овоо ХК-аас нийгмийн хариуцлагын хүрээнд Хаялага нуурын эргэн тойрны хог хаягдлыг цэвэрлэж, 9.7 м³ хуримтлагдсан хогийг хогийн цэг рүү ачиж зайлуулах ажлыг зохион байгуулан ажилласан.

Аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх 2021 оны арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан “Отоглох цэгүүдэд стандартын тэмдэг, тэмдэглэгээний самбар байршуулах” ажлыг 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдөр “Жавхлант ариувжих” ХХК-иар гүйцэтгүүлж, нийт 8 газарт отоглох цэгийг тэмдэгжүүлж мэдээллийн самбар байршуулсан бол, Хүүхдийн овоо, Зүүн Чойрын хийдийн туурийг иргэдэд сурталчлах зорилгоор гантиг чулуун самбаруудыг байршуулаад байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах, зүй зохистой ашиглах талаар 2021 онд байгалийн нөөцийн хамтын менежментийн “Уулзварын гол” нөхөрлөлтэй гэрээ байгуулж, хамтран хэрэгжүүлэх төлөвлөгөө батлуулан ажиллаж байна. Төлөвлөгөөний хүрээнд малчдын бэлчээр ашиглалтын бүлэг, байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлтэй хамтран тусгай хамгаалалттай газрын ойролцоох 24.3 га бэлчээрийг чөлөөлүүлж, чөлөөлсөн бэлчээрийг хамгаалах, сайжруулах, зохистой ашиглах ажлыг эхлүүлж, малчин өрхүүдийн бэлчээр чөлөөлөх ажил 60.0 хувьтай явагдаж байна.

2021 оны Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хүрээнд 6.5 сая төгрөгийн санхүүжилтээр “Жавхлант Арвижих” ХХК-тай гэрээ байгуулан “Цоорхойн рашааны хамгаалалтын хашаа, хөв цөөрмийг сэргээн засварлах, “Ногоон төгөл – Ногоон паспорт” бичил цэцэрлэгт явган хүний болон машин орох хаалга хийх ажлыг хийж гүйцэтгэсэн.

2021 оны Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 5.0 сая төгрөгийн санхүүжилтээр Сүмбэр сумын 4 дүгээр багийн нутаг “Гашууны булаг”-ийн эхийг хашиж хамгаалах ажлыг багийн иргэдийн оролцоотойгоор хийж гүйцэтгэхээр бэлтгэл ажлыг хангаж “Гашууны эх” иргэдийн бүлэгтэй гэрээ байгуулаад байна.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, хөрөнгө оруулалтын талаар: Монгол улсын Ерөнхий сайдын 2020 оны 05 дугаар захирамжаар “Атар-4 тариалангийн тогтвортой аян”-ыг орон даяар хэрэгжүүлэхтэй холбогдон гаргасан чиглэлийн дагуу газрын мониторингийн цахим системд оруулах мэдээллийн санг нэгдсэн зааврын дагуу 15 аттирбути мэдээллийг үүсгэсэн.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 2/1251 тоот албан бичгээр “Хот, тосгон, бусад суурин газрын үнэлгээний бүс, 1 га газрын суурь үнийн санал” авах чиглэлийн хүрээнд олон нийтээс 2021 оны 07 дугаар сарын 12-19-ний өдрүүдэд “Говьсүмбэр аймгийн Газрын алба” цахим хаягаар болон “Чойр зар” цахим хуудас, олон нийтийн сүлжээнд ил тод байршуулан, нийт 163 иргэнээс санал авч ажилласан.

Нэгж талбарын хувийн хэргийг цахим архивт шилжүүлэх зорилгоор аймаг, сумдын Засаг даргын захирамжаар олгогдсон нийт 1983 нэгж талбараас 880 нэгж талбарыг скайнердаж цахим архив үүсгэн ажиллаж байна.

Сууц өмчлөгчдийн холбооны хэвийн үйл ажиллагааг хангахад тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, нийтийн эзэмшлийн талбайн цэвэрлэгээ, үйлчилгээ чанар хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор Аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/155 дугаар захирамжийн дагуу “Бадрах 70” СӨХ-ны үйл ажиллагаа, санхүүгийн баримтад хяналт шалгалт хийсэн.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Сүмбэр суманд баригдаж буй 640 хүүхдийн хүчин чадалтай сургуулийн барилгын ажлын гүйцэтгэл 85 хувьтай явагдаж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Сүмбэр сумын 1 дүгээр байрны гадна авто зогсоол тохижилтын ажил хийгдэж дууссан бөгөөд ашиглалтад хүлээн авлаа.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Сүмбэр сумын 2,3 дугаар багийн нутаг дэвсгэрт явган хүний зам тавих ажил 25 хувийн гүйцэтгэлтэй, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Шивээговь суманд баригдах 320 хүүхдийн сургуулийн барилга угсралтын ажил эхлэх шатанд, Сүмбэр сумын 2 дугаар багийн айл өрхийг цэвэр усны шугамд холбох тэрэгтийн эх үүсвэрийн тоног төхөөрөмж солих ажлын нийт гүйцэтгэл 98 хувьтай хийгдэж байна.

Орон нутгийн өмч, худалдан авах ажиллагааны талаар: Төсвийн ерөнхийлөн захирагчид 2021 онд нийт 5,275,988.8 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 24 бараа, ажил, үйлчилгээ худалдан авч хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 20 тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зарласан.

2021 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 2 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 2 ажил, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 15 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 14, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нийт 5 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 4, Авто замын сангийн хөрөнгө оруулалт, Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдэх тус бүр 1 ажлын тендер шалгаруулалтыг зарлан, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулаад байна.

Зарлагдсан тендерийн урилгуудыг “Монголын үнэн” сонин, www.tender.gov.mn, govisumber.gov.mn сайтуудад тухай бүр нийтэлж, тендер шалгаруулалтыг 100 хувь цахим хэлбэрээр явуулж байна. Тендер шалгаруулалты үр дүнг тухай бүрт нь цахим системд оруулсан.

Орон нутгийн өмчийн түрээсийн орлогод 36.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 07 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 17.5 сая төгрөгийг төвлөрүүлж буюу 48.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

ДОЛОО. СУМ ОРОН НУТГИЙН ТАЛААР

Баянтал сум: Ковид-19 цар тахал, малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор бэлчээр чөлөөлөх ажлыг зохион байгуулж, төмөр замын 8 нүхэн гарц, гармыг хааж, сумруу орох, гарах хөдөлгөөнийг хязгаарлан ажилласан.

Бэлчээр чөлөөлөх ажлыг зохион байгуулж, оторлож байгаа 64 малчин өрхөд сумын Засаг даргын захирамжийг танилцуулж мэдэгдэх хуудас өгөн ажилласан.

Сумын Засаг даргын А/44 дүгээр захирамжийн дагуу 2021 оны 4 дүгээр сарын 26-10 дугаар 15-ны хооронд ноолуурын ашиг шимийн хэмжилт, ангилалт бүртгэлжүүлэлтийн ажил хийж, 32 өрхийн 7086 малыг хамруулж, ноолуурын дундаж гарц 485.5 гр байгааг тодорхойлсон.

Бэлчээрийн хортон мэрэгчдийн тархалтын тандалт судалгааг Шилийн худаг, Шилийн тээг, Сүүл толгойн ар, Лүнгийн зүүн хойд тал, Цэрдгэрийн баруун тал, 621-ийн зүүн тал зэрэг газруудад хийсэн бөгөөд мэрэгчдийн тоо сийрэг байгаа боловч 3 цэгт олшрох хандлагатай байна.

Шивээговь сум: Аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/172 дугаар захирамжийн хүрээнд төмөр замын 22 дугаар зөрлөгийн гарам дээр хяналтын постыг байгуулан, 24 цагаар ажиллуулж, иргэд болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавин ажиллаж байна. Мөн олон нийтийн арга хэмжээ, хурал цуглааны үйл ажиллагааг хязгаарлан, архи согтууруулах ундааг худалдах, худалдаа үйлчилгээний газруудын ажиллах цагийн хуваарийг өглөөний 08:00-21:00 цагийн хооронд явуулж байна.

Суманд 6 иргэн, 1 байгууллага 14.22 га талбайд усалгаатай газар тариалан эрхэлж байна. Үүнд: хүнсний ногоо 4.2 га, төмс 10.02 га талбайд, 180м² хүлэмжинд нарийн ногоо тус тус тариалаад байна. Байгалийн гамшиг мөндөрт цохиулсан газар тариалан эрхлэгч гурван иргэнд хүлэмж олгосон.

Сүмбэр сум: 2021 онд ажил үйлсээрээ шалгаран “Сумын аварга малчин өрх”-ийн болзлыг хангасан 4 малчин өрхөд шагналыг нь гардуулах ажлыг зохион байгууллаа.

Сум хөгжүүлэх сангаас авсан хугацаандаа төлж барагдуулаагүй болон чиглэлийн дагуу үйл ажиллагаа явуулаагүй 21 иргэнд сумын Засаг даргын “Төлбөр төлж барагдуулах тухай” албан бичгийг хүргүүлсэн. 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар нийт 19 зээлдэгч зээлээ бүрэн төлж барагдуулан, 16 зээлдэгч зээлийн эргэн төлөлтөө төлж, нийт 195.6 сая төгрөгийн зээлийг эргэн төвлөрүүлээд байна.

“Бэлчээр хамгаалах ажлыг эрчимжүүлэх тухай” Засгийн газрын 2019 оны 185 дугаар тогтоолын хүрээнд бэлчээр хамгаалах, сайжруулах, зохистой ашиглах, оновчтой төлөвлөх сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Бэлчээр хамгаалах улирал” аяныг зохион байгуулж “Уулзварын гол” нөхөрлөлийн гишүүдтэй уулзалт зохион байгуулан, хамтран ажиллаж байна.

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР